

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)

Өлгий хот

2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч:
Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99998909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

“БАЯН-ӨЛГИЙ ЦАХИЛГААН
ШУГАМ СҮЛЖЭЭ” ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Ө.АРМАНБЕК
ТАНАА

2026.02.25 № 373
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Баян-Өлгий Цахилгаан шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нь 2025 онд 32,912.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж 32,728.7 сая төгрөгийн зардал гаргаж 183.6 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832605060426

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЖЕНИСБЕК



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,629,841,455.48	653,907,227.80
1.1.2	Дансны авлага	2,381,042,797.51	2,469,730,621.42
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	37,691,315.29	312,930,673.07
1.1.4	Бусад авлага	26,006,733.00	63,776,733.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,033,424,728.84	2,744,440,902.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,108,007,030.12	6,244,786,158.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,437,923,813.50	16,002,084,160.97
1.2.2	Биет бус хөрөнгө	140,036,800.00	140,036,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,577,960,613.50	16,142,120,960.97
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,685,967,643.62	22,386,907,119.09
2.1.1.1	Дансны өглөг	1,388,040,311.92	1,963,675,117.50
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	3,736,302.83	32,870,775.43
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,391,776,614.75	1,996,545,892.93
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,136,587,736.70	2,136,587,736.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,528,364,351.45	4,133,133,629.63
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	10,698,433,754.84	19,610,929,218.84
2.3.2	· хувийн		
2.3.3	· хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	480,277,808.77	480,277,808.77
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,069,035,134.00	2,069,035,134.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,090,143,405.44)	(3,906,468,672.15)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,157,603,292.17	18,253,773,489.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,685,967,643.62	22,386,907,119.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	17,383,091,016.19	27,804,154,402.44
2	Борлуулалтын өртөг	12,523,287,885.80	26,285,429,469.88
3	Нийт ашиг(алдагдал)	4,859,803,130.39	1,518,724,932.56
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	18,230,826.21	6,611,730.47

6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	429,364,767.97	5,101,581,974.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	29,591,573.80	49,641,761.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	254,328,052.33	183,947,883.91
11	Санхүүгийн зардал	4,402,773,710.40	5,677,818,132.74
12	Бусад зардал	462,109,620.82	511,427,821.38
13	Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэнолз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	158,595,767.22	204,083,037.11
19	Орлогын татварын зардал	15,859,536.72	20,408,303.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	142,736,230.50	183,674,733.41
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	142,736,230.50	183,674,733.41
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү		
	Бусадолз (гарз)		
24	Орлогын нийт дүн	142,736,230.50	183,674,733.41

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	1,425,949,420.00	(4,251,801,381.46)	8,352,859,602.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				18,921,445.41	18,921,445.41
Залруулсан үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	1,425,949,420.00	(4,232,879,936.05)	8,371,781,047.56
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				142,736,530.49	142,736,530.49
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			643,085,714.00		643,085,714.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-

2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	2,069,035,134.00	(4,090,143,405.56)	9,157,603,292.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
Залруулсан үлдэгдэл	10,698,433,754.84	480,277,808.77	2,069,035,134.00	(4,090,143,405.56)	9,157,603,292.05
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				183,674,733.41	183,674,733.41
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	8,912,495,464.00		-		8,912,495,464.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	19,610,929,218.84	480,277,808.77	2,069,035,134.00	(3,906,468,672.15)	18,253,773,489.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,160,290,780.10	24,212,404,282.69
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	13,490,194,453.36	23,340,417,346.03
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	69,755,539.03	27,476,301.46
	Хүүгийн орлого	1,670,866,373.00	8,197,360.93
	Бусад мөнгөн орлого	929,474,414.71	836,313,274.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,293,255,054.57	8,408,338,510.37
	Ажиллагчдад төлсөн	2,016,532,971.00	3,140,643,064.19
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	661,981,674.03	854,588,012.17
	Бараа материал худалданавахад төлсөн	109,694,493.64	156,444,022.20
	Ашиглалтын зардалд төлсөн	-	571,975.99
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,111,261,852.40	1,714,303,840.00
	Хүүний төлбөрт төлсөн	7,352,100.00	665,544.64
	Татварын байгууллагад төлсөн	871,743,469.33	684,060,372.31
	Даатгалын төлбөрт төлсөн	8,451,737.00	7,965,678.00
	Бусад мөнгөн зарлага	2,506,236,757.17	1,849,096,000.87
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,867,035,725.53	15,804,065,772.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,970,400,005.70	16,780,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	220,400,005.70	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусадад олгосон зээл		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	8,750,000,000.00	16,780,000,000.00

2.3	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн	(8,970,400,005.70)	(16,780,000,000.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(103,364,280.17)	(975,934,227.68)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,733,205,735.65	1,733,205,735.65
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,629,841,455.48	1,629,841,455.48

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	17,383,091,016.19	26,393,409,759.91	27,804,154,402.44	-1,410,744,642.53	151.83
Үйлдвэрлэлийн байгууллага	762,605,283.00	4,255,808,437.91	4,208,738,391.19	47,070,046.72	558.06
Худалдаа үйчилгээний байгууллага	4,126,124,026.00	2,487,251,670.03	3,538,466,454.39	-1,051,214,784.36	60.28
Төсөвт байгууллага	1,521,808,117.00	2,014,970,085.00	2,507,442,213.44	-492,472,128.44	132.41
Орон сууц	721,961,745.71	1,457,638,548.00	1,335,880,988.65	121,757,559.35	201.90
Гэр хороолол	5636681418.48	10,113,010,318.97	10,148,895,654.77	-35,885,335.80	179.41
Түгээх үйлчилгээний орлого	4,613,910,426.00	6,064,730,700.00	6,064,730,700.00	0.00	131.44
Нийт орлого	17,830,686,610.37	26,515,880,641.91	32,912,348,106.96	-6,396,467,465.05	148.71
Үүнээс: Цэвэр борлуулалт	17,383,091,016.19	26,393,409,759.91	27,804,154,402.44	-1,410,744,642.53	151.83
Хүүгийн орлого	18,230,826.21	7,546,300.00	6,611,730.47	934,569.53	41.39
Бусад орлого	429,364,767.97	114,924,582.00	5,101,581,974.05	-4,986,657,392.05	26.77
Нийт зардал	17,687,950,079.87	26,393,409,759.91	32,728,673,373.56	-6,335,263,613.65	149.22
Үүнээс:					
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	12,523,287,885.80	21,069,470,180.00	26,285,429,469.88	-5,215,959,289.88	168.24
б) Ерөнхий ба удирдлагын зардал	254,328,052.33	190,947,883.91	183,947,883.91	7,000,000.00	75.08
в) Хөрөнгө оруулалт их засвар	666,634,006.00	1,025,100,000.00	737,504,000.00	287,596,000.00	153.77
г) элэгдлийн зардал	1,092,162,774.36	1,025,071,556.00	1,178,958,249.54	-153,886,693.54	93.86
д) Орлогын албан татвараас бусад татвар	5,539,750.00	9,063,800.00	8,988,407.17	75,392.83	163.61
е) Үйл ажиллагааны зардал	3,130,138,074.66	3,073,756,340.00	4,313,437,059.36	-1,239,680,719.36	98.20
Орлогын албан татвар	15,859,536.72		20,408,303.70		-
Цэвэр ашиг, алдагдал	142,736,530.50	122,470,882.00	183,674,733.40	-61,203,851.40	77.71

